



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/34

Ховд

Хорио цээрийн дэглэмийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Чандмань, Дөргөн, Мянгад, Ховд, Эрдэнэбүрэн, Цэцэг сумдад малын гоц халдварт шүлхий өвчний халдварын тохиолдол үргэлжилж, хорио цээрийн дэглэм хэрэгжиж байгаатай холбогдуулан малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, бусад сумдад халдвар дахин дэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн Ховд аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хорио цээрийн дэглэмийг шинэчлэн тогтоосугай.

2. Ховд аймгаас гадагш гарах болон бусад аймгаас Ховд аймгийн нутагт орох, Ховд аймгийн сум хооронд отор нүүдэл хийх, худалдаа, арилжаа, үзэсгэлэн, уралдаан болон бусад зориулалтаар малын шилжилт хөдөлгөөн хийх, нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэхийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хориглосугай.

3. Мал амьтны гоц халдварт Шүлхий өвчинтэй тэмцэх зааврын дагуу шүлхий өвчинтэй тэмцэх, тархвар зүйн судалгаа хийх, халдваргүйжүүлэлт, дархлаажуулалтын ажлыг шуурхай зохион байгуулж өвчний тархалтыг таслан зогсоохыг Мал эмнэлгийн газар (Д.Батцэнгэл), хорио цээрийн дэглэмийг хэрэгжүүлж, шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг сумын хэмжээнд хариуцан зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Өвчлөл илэрсэн сум, багийн голомтын бүсээс гадагш гарах хүн мал, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүрэн зогсоож, хяналтын постуудад хүн хүч, техник хэрэгсэл нэмэгдүүлж, гамшгийн үеийн шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газар (Б.Алтанбадралт), бүх нийтийн хөдөлгөөнд

хяналт тавьж, хэв журам сахиулж ажиллахыг Цагдаагийн газар (Д.Мөнхболд) нарт тус тус даалгасугай.

5. Шүлхий өвчний тархалтыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор сум, баг хоорондын хүн, мал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, отор нүүдэлд хязгаарлалт хийж, эрүүл сум, баг, бүс нутгийг халдвараас хамгаалж ажиллахыг нийт сум, багийн Засаг дарга нарт, шилжилт хөдөлгөөнд хатуу хяналт тавьж, захирамж зөрчсөн иргэн хуулийн этгээдэд, хуулийн дагуу арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлж, хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн бүх шатны улсын байцаагч нарт үүрэг болгосугай.

6. Шүлхий өвчнөөр тайван сумдаас аймгийн иргэдийн хүнсний хэрэгцээнд зориулж Мал эмнэлгийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан мал эмнэлгийн гэрчилгээтэй мал, мах, сүү, бусад бүтээгдэхүүн нэвтрүүлэхийг зөвшөөрсүгэй.

7. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн А/441 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

8. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, цаг үеийн шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Т.Жаргалсайхан) Мэргэжлийн хяналтын газар (П.Эрдэнэчулуун) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ДҮГЭРЖАВ